



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 54

Улаанбаатар хот

“Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны стратеги”-ийн хүрээнд
үнэт цаасны салбарт 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны
төлөвлөгөөг батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, 34.1.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн “Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны стратеги” батлах тухай 117 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны стратеги” –ийн хүрээнд үнэт цаасны салбарт 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсугай.
2. Зарим тэргүүлэх чиглэлээр төсөл боловсруулан олон улсын байгууллага бусад хандивлагчдад хандан санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхийг Хорооны дарга /Д.Баярсайхан/-д үүрэг болгосугай.
3. Энэхүү төлөвлөгөөг олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд, Ажлын албаны жил бүрийн төлөвлөгөөнд тусгах замаар хэрэгжилтийг зохион байгуулахыг Үнэт цаасны газар /Б.Саруул/-т тус тус даалгасугай.


ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000103

Санхүүгийн зохицуулах хорооны
2013 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн
54 дүгээр тогтоолын хавсралт



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО
ҮНЭТ ЦААСНЫ ГАЗАР

“САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ”-ИЙН ХҮРЭЭНД
ҮНЭТ ЦААСНЫ САЛБАРТ 2012-2016 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2013 он

1. Оршил	3
2. Нийтлэг үндэслэл	
2.1. Санхүүгийн салбарын хүрсэн ололт, амжилт ба тулгарч буй сорилтын тойм	4
2.2. Үндэсний хөгжлийн цогц бодлого	5
2.3. Үндэсний хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэхэд үнэт цаасны зах зээлийн гүйцэтгэх үүрэг	5-6
3. Нөхцөл байдлын шинжилгээ	7
3.1. Үнэт цаасны салбарын хүрсэн ололт, амжилт, тулгарч буй сорилт, сургамж.....	7-13
4. Стратеги төлөвлөгөө	14
4.1. Эрхэм зорилго	14
4.2. Хэтийн зорилго	14
4.3. Стратеги зорилго ба түүнийг хэрэгжүүлэх хөтөлбөр	14-15
4.4. Стратеги зорилгыг хэрэгжүүлэх хөтөлбөр, түүний төлөвлөгөө	16-25
5. Хүлээгдэж буй үр дүн	26
6. Санхүүжилт	26
7. Төлөвлөгөөний удирдлага, хяналт шалгалт, тайлагнал	26

1. Оршил

Монгол Улсын үнэт цаасны зах зээл 20 жилийг ардаа орхиж энэ хугацаанд хөгжлийн үе шатуудыг дамжин өнөөдрийн түвшинд хүрчээ. Шинээр бий болж буй зах зээлийн хувьд олон бэрхшээлийг туулж, багагүй амжилтад хүрсэн ч цаашид хийж гүйцэтгэх олон ажил, давж гарах олон даваа бидний өмнө байна.

Санхүүгийн зохицуулах хороо 2006 онд байгуулагдсан цагаасаа төрийн зохицуулагч байгууллагын хувьд үнэт цаасны зах зээлд төрийн хууль тогтоомж хэрэгжүүлэх үүргийг гүйцэтгэхээс гадна тус зах зээлд төрийн бодлогыг тодорхойлж цаашдын чиглэлийг тогтооход өөрийн үүргийг гүйцэтгэж ирсэн. Бид 2009 оноос хойш өөрийн эрхлэх үйл ажиллагааны хүрээнд зах зээл дэх мэргэжлийн байгууллагуудын санаа бодлыг харгалзан зохицуулагч байгууллагын хувьд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг батлан, түүнийхээ дагуу цаашдын 4 жилийн үйл ажиллагааг хөтлөн явуулж ирсэн бөгөөд энэ удаа 2012-2016 оны төлөвлөгөөг залгамж болгон баталж байна.

2. Нийтлэг үндэслэл

2.1. Санхүүгийн салбарын хүрсэн ололт амжилт ба тулгарч буй сорилтын тойм

Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын дараа манай улсын эдийн засаг богино хугацаанд сэргэн 2011 онд манай улсын эдийн засаг 17.3 хувиар өсч, дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ нэрлэсэн үнээр 10829.7 тэрбум төгрөгт хүрсэн.

Өнгөрсөн 10 жилд Монгол Улсын эдийн засгийн өсөлт өндөр байсан хэдий ч уул уурхайд суурилсан жижиг эдийн засаг хэвээр байгаа төдийгүй хөгжлийн олон сорилттой тулгарч байна. Монгол улсын эдийн засгийн өсөлт дэлхийн зах зээл дээрх ашигт малтмалын анхдагч бүтээгдэхүүний үнэ, эрэлтээс хамааралтай хэвээр байна. Түүнчлэн ажилгүйдлийн түвшин хэдийгээр буурч байгаа боловч өндөр хэвээр¹, хүн амын ядуурлын түвшин 29.8 хувь², орлого хуваарилалт тэгш бус³, дэд бүтцийн хөгжил дорой, засаглал сул төдийгүй авилгалд өртөмтгий⁴ зэрэг шийдвэрлэх олон асуудал байгааг дурьдаж болно.

Санхүүгийн салбарт тулгарч буй сорилтуудыг нэрлэвэл, нэгдүгээрт санхүүгийн зах зээлийн тэнцвэрт байдал алдагдсан, банкны салбар хэт давамгайлсан, хоёрдугаарт санхүүгийн зах зээл нь эдийн засгийн эрчимт өсөлтөө гүйцэхгүй байх төлөв ажиглагдаж байгаа бөгөөд Монгол Улсын санхүүгийн зах зээлийн өнөөгийн зохицуулалтын бүтцийг харахад нийт санхүүгийн салбарын 4.4 хувийг Санхүүгийн зохицуулах хороо, үлдсэн 95.6 хувийг Монголбанк дангаараа зохицуулж байна. Монгол Улсад банкны салбар хэт давамгайлсан энэ байдал нь ирээдүйд банкны салбарт үүссэн хүндрэл санхүүгийн секторт нөлөө үзүүлэх үр дагавартай тул санхүүгийн секторын хөгжлийг сааруулах, цаашилбал хямралд хүргэж болзошгүй юм.⁵

Банкнаас бусад санхүүгийн салбарын өсөлтийг дэмжих төрийн бодлогын бичиг баримтууд батлагдсан боловч бодит санхүүгийн дэмжлэг дутмаг байна. Үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн хөгжил хангалтгүй, хаалттай төдийгүй нээлттэй компаниудад компанийн сайн засаглал бүрэлдээгүй, үнэт цаасны зах зээлийг хувьчлалын арга хэрэгсэл болгосны үр дагавар арилаагүй, уг зах зээлийн талаарх нийтийн мэдлэг мэдээлэл сул хэвээр байгаа нь үнэт цаасны зах зээл эдийн засгийн өсөлттэй зэрэгцэн хөгжихөд саад болж байна.

¹ Ажилгүйдлийн түвшин 2010 онд 13 хувь байсан боловч 2011 онд 11 хувь болж бууржээ. Эх сурвалж: World Bank, Mongolia Quarterly Economic Update - February 2012.

² Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2012.

³ Орлого хуваарилалтын тэгш бус байдлыг үзүүлдэг Жини Индексээр хамгийн сүүлийн 2008 оны байдлаар Монгол улс нь 36.5 хувь буюу Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн улсуудын дундаж үзүүлэлтээс 90 дахин их байна. Эх сурвалж: CIA, The World Factbook. <https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/rankorder/2172rank.html> сайтаас үзнэ үү.

⁴ World Bank Institute. Worldwide Governance Indicators, Country Data report for Mongolia 1996-2011.

⁵ Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 117 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны стратеги”, 15 дугаар хуудас, хүснэгт 5.

Үнэт цаасны салбар нь банкуудтай өрсөлдөн санхүүгийн хуримтлалыг бодит сектор луу дамжуулан хөрөнгө оруулалт хийх суваг болж, санхүүгийн зуучлалын өрсөлдөөнийг гүнзгийрүүлэн, хүү ханшны тогтвортой байдлыг хангах боломжийг нээдэг байх ёстой.

2.2. Үндэсний хөгжлийн цогц бодлого

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод хувийн хэвшил тэргүүлсэн эдийн засгийг эрчимтэй өсгөх замаар Мянганы хөгжлийн зорилтын биелэлтийг хангаж, дундаж хөгжилтэй улс болгох зорилтыг дэвшүүлсэн билээ.

Уг бодлогод 2007-2015 онд Мянганы хөгжлийн зорилтыг хангах, эдийн засгийг эрчимтэй хөгжүүлэх, 2016-2021 онд мэдлэгт суурилсан эдийн засагт шилжих хоёр үе шатыг тодорхойлсон. Эдгээр үе шатыг дамжин хэрэгжих Монгол Улсын хөгжлийн 2 дугаар тэргүүлэх чиглэл, мөнгө зээлийн бодлогын хүрээнд санхүүгийн тогтолцоо, үйлчилгээг боловсронгуй болгож хөрөнгө оруулалт, бизнесийн таатай орчин бүрдүүлэх дэд зорилт дэвшүүлсэн.

Уг дэд зорилтын хүрээнд дор дурдсан ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- Банк, санхүүгийн тогтолцоог хөгжлийн өндөр түвшинд хүрсэн орнуудын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох;
- Банкны байгууллагаас үзүүлэх санхүүгийн үйлчилгээг нийтлэг хэлбэрээр явуулах;
- Төрийн өмчийн "Хөгжлийн банк"-ыг байгуулж ажиллуулах, банкны төлбөрийн чадварыг сайжруулж, банк, санхүүгийн зах зээлд шударга өрсөлдөөн төлөвшүүлэх;
- Үнэт цаас, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өрсөлдөх чадвар бүхий үнэт цаасыг гадаад зах зээлд гаргаж, хөрөнгийн гадаад эх үүсвэрийг нэмэгдүүлэх;
- Засгийн газрын үнэт цаасны арилжааг, ялангуяа хөрөнгө оруулалтын чиглэлээр өргөтгөх, ипотекийн нэгтгэлийн үйл ажиллагааг жигдрүүлэх;
- банк, санхүүгийн байгууллагын зах зээлд суурилсан хяналт шалгалтын удирдлагыг боловсронгуй болгох;
- Улаанбаатар хотыг Зүүн хойт Ази, Төв Азийн бүс нутгийн банк, санхүүгийн томоохон төв болгохыг зорих, экспортын үйлдвэрлэлийг дэмжих зорилготой нэгтгэл, холбоо, экспорт-импортын банк зэрэг төрөлжсөн байгууллагуудыг байгуулж, дэмжиж ажиллахаар заасан.

2.3. Үндэсний хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэхэд үнэт цаасны зах зээлийн гүйцэтгэх үүрэг

Үндэсний хөгжлийн цогц бодлогод тусгасан хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх зорилтын хүрээнд эдийн засгийн бодит сектор болон түүний санхүүгийн салбарт гүйцэтгэх үнэт цаасны зах зээлийн үүрэг, ач холбогдлыг үнэлэн, хөгжлийн зорилтыг өөртөө агуулсан томоохон хөтөлбөр, төлөвлөгөө, чиглэлүүд төрийн эрх бүхий байгууллагуудаас батлагдаж байв.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 40 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2011-2013 оны дунд хугацааны зорилт”, Засгийн газрын 2010 оны 115 дугаар тогтоолоор батлагдсан “Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ”, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 228 дугаар тогтоолоор батлагдсан “Хөрөнгийн зах зээлийг 2009-2012 онд хөгжүүлэх үндсэн чиглэл” болон үе үеийн Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг үүнд нэрлэж болно.

Үнэт цаасны зах зээлийг хөгжүүлсэнээр үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо болон тодорхой хөрөнгө оруулалтын өмчлөх эрхийн шилжүүлгийг хялбарчлах замаар хөрөнгө оруулалтыг дэмжих, зээлээс гадна үнэт цаас гаргаж хөрөнгө татах боломжийг бизнесийн байгууллагуудад олгох, үнэт цаасжуулах замаар биет хөрөнгийг эргэлтийн хөрөнгө болгон хувиргах, олон нэр төрлийн бүтээгдэхүүн гаргах замаар богино болон урт хугацааны хөрөнгө оруулалт хийх нөхцлийг бүрдүүлэх ач холбогдолтой бөгөөд энэ нь дотоодын төдийгүй гадаадын хөрөнгө оруулалтыг хялбараар татах, хувийн хэвшил дэх банкнаас бусад санхүүжилтийг дэмжих, улмаар дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, цашилбал өөрийгөө тэтгэх, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай эдийн засгийг бүрдүүлэх чухал алхам болох юм.

Түүнчлэн мэргэжлийн байгууллагуудын эрсдлээс хамгаалах тогтолцоог бүрдүүлж, зах зээл дэх бүтээгдэхүүн, үйлчилгээ болон оролцогчдын мэдээлэл түргэн шуурхай түгэх, үнэт цаасны ханшаар илэрхийлэгдэх хөрөнгө оруулалтын үнэ бодитоор тогтох боломжийг бүрдүүлэх давхар ач холбогдолтой.

3. Нөхцөл байдлын шинжилгээ

3.1. Үнэт цаасны салбарын хүрсэн ололт, амжилт, тулгарч буй сорилт, сургамж

Үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэхэд чиглэсэн Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 115 дугаар тогтоолоор батлагдсан “Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ”, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 228 дугаар тогтоолоор батлагдсан “Хөрөнгийн зах зээлийг 2009-2012 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлж ажиллаа. Тэдгээрийг хэрэгжүүлэх явцад олон сорилт, бэрхшээл тулгарч байснаас гадна тодорхой ололт амжилтад хүрсэн.

Эдгээрийг “Хөрөнгийн зах зээлийг 2009-2012 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-д тусгасан (I) хөрөнгө оруулалтын эрхийн бичгийн хувьчлалын зарим сөрөг үр дагаврыг залруулах, (II) зах зээлийн дэд бүтцийг бэхжүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, (III) зах зээл дэх бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, хөрвөх чадварыг сайжруулах, (IV) хөрөнгө оруулагчдыг идэвхжүүлэх, тэдний эрх ашгийг хамгаалах, зах зээлийн бус эрсдлийг бууруулах, томоохон сангууд хөрөнгийн зах зээлд оролцох боломжийг бүрдүүлэх замаар хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, (V) Үнэт цаасны зах зээлийн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилтуудын хүрээнд шинжилгээ хийлээ.

I. Хөрөнгө оруулалтын эрхийн бичгийн хувьчлалын зарим сөрөг үр дагаврыг залруулах зорилтын хүрээнд

Амжилт

1. Өмч хувьчлалын сөрөг үр дагаврыг залруулахад уг хувьчлалын явцад бий болж хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэгдсэн компанийг зэрэглэх, улмаар хөрөнгө оруулагчид мэдээлэлд суурилсан шийдвэр гаргахад дэмжлэг болох шаардлагын үүднээс тус Хороо хуулийн үйл ажиллагаа, үнэт цаас, зээлжих чадвар, бонд болон түүнтэй адилтгах өрийн бичигт дүн шинжилгээ хийж, эрсдлээр нь ангилан зэрэглэл тогтоох үйл ажиллагаа зайлшгүй хэрэгтэй гэж үзсэн.

Иймд Хорооны 2010 оны 4 дүгээр сард 97 дугаар тогтоолоор “Зэрэглэл тогтоох этгээдэд эрх олгох, үйл ажиллагааг бүртгэх журам” баталсан болно. Уг журмаар зэрэглэл тогтоох үйл ажиллагааг хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх, уг хуулийн этгээдэд Хороо эрх олгохоор заасан. Одоогийн байдлаар зөвхөн нэг хуулийн этгээдэд уг эрхийг олгоод байна.

2. Өмч хувьчлалын сөрөг үр дагаврыг залруулах үүднээс үйл ажиллагаа нь зогссон компаниудыг дахин хөрөнгөжүүлэх, татан буулгах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд эрх зүйн үндэс дутагдаж байсныг 2010 оны 10 дугаар сард батлагдсан Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгаж компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багассан тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөл буюу гүйцэтгэх удирдлага хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлаж, хувь нийлүүлсэн хөрөнгөд өөрчлөлт оруулах,

компанийг дахин хөрөнгөжүүлэх, эсхүл татан буулгах асуудлыг шийдвэрлүүлэх үүрэгтэй байхаар тусгасан. Компанийн удирдлага шийдвэр гаргаагүй тохиолдолд Санхүүгийн зохицуулах хороо тухайн компанийг шүүхийн журмаар татан буулгах шийдвэр гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй байхаар зохицуулалтыг тусгасан нь цаашид уг асуудлыг цэгцлэхэд тодорхой түлхэц болохоор байна.

3. Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор 2011 оны 1 дүгээр сард 28 дугаар тогтоолоор “Монголын хөрөнгийн бирж” ХК-д үнэт цаасыг ангилан арилжихыг үүрэг болгосон. Уг үүргийн дагуу МХБ 2011 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс хувьцаат компанийн үнэт цаасыг хувь нийлүүлсэн хөрөнгө, үнэт цаасны үнийн дүнд эзлэх эргэлтийн бус хөрөнгийн хэмжээ, ашиг, алдагдал, хувьцаа эзэмшигчдийн тоо, олон нийтэд санал болгосон хувь зэрэг үндсэн шалгуур, зах зээлийн үнэлгээ, үнэт цаас арилжигдсан өдрийн тоо зэрэг нэмэлт шалгуурыг үндэслэн А болон Б самбарт хуваарилан арилжиж байна.

4. 2012 оны байдлаар 330 хувьцаат компани Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэйгээс төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой 55, хувийн өмчийн 275 компани үйл ажиллагаа явуулж байна. Өнгөрсөн хугацаанд хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлаа хийж, хурлын материалаа Хороонд ирүүлсэн хувьцаат компанийн тоо 159 болсон нь өмнөх оноос даруй 25 хувиар нэмэгдсэн дүнтэй байна. Энэ нь Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж тодорхой үүрэг, хариуцлагыг компанийн удирдлагуудад хүлээлгэснээс гадна уг компаниудад хувьцаат компани хэвээр үлдэх сонирхлыг бий болгосонтой холбон тайлбарлаж болно.

5. 2006 оноос гадаадын иргэд, хуулийн этгээдээс Монгол улсад шууд болон шууд бусаар хөрөнгө оруулах сонирхол идэвхжиж, тэдгээрийн оролцоо огцом нэмэгдсэнтэй холбоотойгоор Хөрөнгийн биржид арилжаалагдаж буй хувьцаат компаниудын үнэт цаасны үнэ, ханшид өсөх хандлага бий болсон.

Анхдагч зах зээлийн хувьд 2005-2012 онуудын хооронд нийт 17 хувьцаат компани Санхүүгийн зохицуулах хороонд үнэт цаасаа бүртгүүлэн шинээр болон нэмж үнэт цаас гаргаад байгаа бөгөөд дээрх компаниудын хувьцааны арилжаа нь “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн нийт арилжааны 23.4 хувийг эзэлж байна. Шинээр болон нэмж үнэт цаас гаргасан хувьцааны бүтцийг авч үзвэл 53 хувь нь олборлох болон боловсруулах салбарын аж ахуй нэгжүүд байна. Үүнээс үзэхэд, аж үйлдвэрлэлийн олборлох болон боловсруулах салбарын аж ахуйн нэгжүүд хөрөнгийн зах зээлээс санхүүгийн эх үүсвэр татаж, түүгээрээ нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөөц бололцоо буйг харуулж байна.

2011 онд “Монголын хөрөнгийн бирж” ХК дээр нийт 252 өдрийн арилжаа хийгдсэн бөгөөд нийт 148 хувьцаат компанийн 122.8 сая ширхэг хувьцаа 109.1 тэрбум төгрөгөөр, Засгийн газрын 2.4 сая ширхэг бонд 236.7 тэрбум төгрөгөөр, компанийн 439.5 мянган ширхэг бонд 4.4 тэрбум төгрөгөөр тус тус арилжаалагджээ.

2012 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар “Монголын хөрөнгийн бирж” ХК дээр нийт 210 өдрийн арилжаагаар 143.2 тэрбум төгрөгийн үнэ бүхий 131.5 сая ширхэг хувьцаа,

309.7 сая төгрөгийн үнэтэй 30.9 мянган ширхэг компанийн бонд, 525.0 мянган төгрөгийн үнэ бүхий 5 ширхэг Засгийн газрын бонд тус тус арилжаалагдсан.

Хувьцааны арилжааны дүн болох 143.2 тэрбум төгрөгийг өмнөх оны жилийн эцсийн дүнд харьцуулахад 34.1 тэрбум төгрөгөөр өссөн хэдий ч нийт арилжааны 88 хувийг буюу 125.9 тэрбум төгрөгийг багцын арилжаа дангаараа эзэлсэн байна.

“Монголын хөрөнгийн бирж” ХК-д үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо, хяналтын “Миллениум Ай Ти” системийг нэвтрүүлэхтэй холбогдуулан хийгдэж буй арилжааны дараахь үеийн буюу төлбөр тооцооны эрсдлийг бууруулах шинэчлэлийн ажлуудын хүрээнд хоёрдогч болон анхдагч зах зээлийн арилжааны платформыг Т+3 хугацааны горимд шилжүүлж байгаа нь эргээд гадаад дотоодын хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах улмаар зах зээлийн хөрвөх чадвар, чадавхийг нэмэгдүүлэх боломжийг бий болгож байна.

6. 2012 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 29 хувьцаат компани 79.1 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараах шийдвэрийг гаргаад байна. Өнгөрсөн хугацаанд хөрөнгийн зах зээл дээр бүртгэлтэй хувьцаат компаниудын хуваарилсан ногдол ашгийн хэмжээ жил бүр өссөн дүнтэй байна. Хэдийгээр ногдол ашиг өгч буй компаниудын тоо харилцан адилгүй байгаа ч нийт тараагдаж буй ногдол ашгийн мөнгөн дүн, нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ тогтмол нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Сорилт

Өмч хувьчлалаас үүссэн сөрөг үр дагаврууд бүрэн арилаагүй хэвээр байгаа нь үнэт цаасны зах зээлийг олон улсын жишигт хүргэхэд томоохон саад учруулсан хэвээр байна.

1. Зэрэглэл тогтоох үйл ажиллагааны үндсийг бий болгосон нь ололт амжилт мөн боловч уг ажиллагаа өнөөдрийн байдлаар зогсонги байдалд ороод байна. Энэ нь зэрэглэл тогтоох этгээдэд эрх олгох, үйл ажиллагааг бүртгэх журамд компанийг зэрэглэх үйл ажиллагааг дэмжих хангалттай хөшүүрэг дутагдалтай байгаатай холбоотой. Тодруулбал, зэрэглэлээ тогтоолгох хүсэлт гаргах үнэт цаас гаргагч нарт уг зэрэглэлийг тогтоолгосноор гарах үр ашиг тодорхойгүй, зэрэглэл тогтоолгоогүйгээс үүсэх үр дагавар эрх зүйн хувьд ч, зах зээлийн механизмын хувьд ч байхгүй байна.

2. Өмч хувьчлалын үр дүнд бий болсон компаниудаас хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж ажиллаж буй хувьцаат компанийн тоо нэмэгдэж байгаа боловч тал хувь нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хохироосон хэвээр байна. Хөрөнгө нь үрэгдсэн компанийг татан буулгах, зохих хууль хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал одоог хүртэл удаашралтай явагдаж байна.

3. Түүнчлэн эдгээр компанийн хувьцааны төвлөрлийн хувь өндөр байгаа нь зах зээлийн хөрвөх чадварыг бууруулж зах зээлийн арилжааны идэвхийг сааруулах нөлөө үзүүлж байна.

II. Зах зээлийн дэд бүтцийг бэхжүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

Амжилт:

1. Хороо мэргэжлийн байгууллагуудын техник, технологи, програм хангамжийн түвшинг сайжруулах замаар үйлчилгээний найдвартай байдал, хүртээмжийг дээшлүүлж зардлыг бууруулан арилжааны явцад хяналт тавих, гадаад орны зах зээлтэй харилцах, хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлэх зорилт дэвшүүлсэн. Энэ ажилд Монгол Улсын Засгийн газар анхаарал хандуулж Лондонгийн Хөрөнгийн бирж групптэй үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэхээр Монголын хөрөнгийн биржийг олон улсын жишигт хүргэх Мастер гэрээ байгуулсан бөгөөд уг гэрээний дагуу “Монголын хөрөнгийн бирж” ХК-д үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо, хадгаламжийн Millennium IT системийг суурилуулан 2012 оны 07 дугаар сарын 02-ны өдрөөс туршилтын журмаар хэрэгжүүлж эхлэн 2012 оны 12 дугаар сарын 17-ны өдөр албан ёсоор хүлээж авлаа.

2. Мэргэжлийн байгууллагад ажиллах боловсон хүчин шинээр бэлтгэх, одоо ажиллаж байгаа мэргэжилтнүүдийн чадавхийг дээшлүүлэх хүрээнд хэд хэдэн чухал ажил хийсэн байна. Үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрх авахад бүгд ижил нэг төрлийн сургалтаар бэлтгэгддэг байсныг өөрчилж брокер, дилерийн, хөрөнгө оруулалтын болон үнэт цаасны арилжаа, төлбөр тооцооны гэсэн 3 чиглэлээр мэргэших нөхцлийг бүрдүүллээ. Сургалтыг зохион байгуулах ажлыг Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоонд шилжүүлэх бэлтгэл ажлыг ханган “Үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтэнд ажил, үйлчилгээ явуулах эрх олгох, аттестатчилах тухай журам”-ыг 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн Хорооны 36 дугаар тогтоолоор баталсан бөгөөд Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны оролцоог хангах үүднээс сургалтуудын үндсэн хөтөлбөрийг тэдний саналыг тусган боловсруулж мөн уг байгууллагын чадавхийг бэхжүүлэх, сургалт шилжүүлэх бэлтгэл ажлыг хангах үүднээс сургалтыг одоогоор хамтран зохион байгуулж байна.

2012 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Хорооноос тусгай зөвшөөрөл аван үйл ажиллагаа явуулж буй арилжаа эрхлэх 1, төлбөр тооцоо хадгаламжийн 1, брокер, дилерийн 94, зэрэглэл тогтоох 1 компани байгаагаас давхардсан тоогоор андеррайтерийн тусгай зөвшөөрөлтэй 25, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх 18 компани байна. Үүнээс гадаадын хөрөнгө оруулалттай 19 брокер, дилерийн компани Хорооноос тусгай зөвшөөрөл аван үйл ажиллагаагаа явуулж байгаа нь гадаадын мэргэжлийн байгууллагын тоо цаашид нэмэгдэх хандлагатайг илэрхийлж байна.

Сорилт

1. Үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо, хадгаламжийн Millennium IT системийг суурилуулсан нь хэдийгээр ололттой алхам болсон боловч уг системийг нэвтрүүлэхтэй холбогдуулан хийгдэж буй арилжааны дараахь үеийн буюу төлбөр тооцооны эрсдлийг

бууруулах шинэчлэлийн ажлууд, тэр дундаа шинэ системийн дагуу биржийн гишүүн брокер, дилерийн компани болон хөрөнгө оруулагч, харилцагчдад тавигдах нөхцлийг хангахад чиглэн хэрэгжүүлэх ажил удаашралтай байна. Ийнхүү удаашралтай байгаа нь биржийн арилжааны хэмжээ, зах зээлийн үнэлгээ, хөрөнгийн биржийн ТОП-20 индексийн үзүүлэлт буурахад нөлөөлсөн. Түүнчлэн, ажиллаж буй брокер, дилерийн компаниудын санхүүгийн чадамж сул, худалдан авах програм хангамж, бусад хураамжийн өртөгтэй холбоотой юм.

Нийт хувьцааны 70-аас дээш хувь нь нэгдмэл сонирхолтой этгээдийн гарт төвлөрсөн хувьцаат компанийг үнэт цаасны бүртгэлээс хасах талаар дорвитой ажил зохиогдоогүй, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах үүднээс зохицуулагч байгууллагуудаас санхүүгийн нэгдэл аж ахуй нэгжүүдийн нэгдсэн хяналтыг бий болгох бодлого баримтлаагүй, уг хяналтыг нэг байгууллага хянан зохицуулах эрх зүйн боломж бүрдээгүй зэрэг нь зах зээлийн хөгжилд тодорхой сөрөг нөлөө үзүүлжээ.

2. Монгол Улсын санхүүгийн зах зээлийн оролцогчдыг зөвхөн бие даасан банк, даатгал, брокер, дилер, банк бус санхүүгийн байгууллагаас бүрдсэн хэмээн тооцох нь өрөөсгөл бөгөөд санхүүгийн салбарын холимог оролцогч болох санхүүгийн нэгдлүүд зах зээлд нэгэнт бий болж, Хорооны зохицуултад хамрагдаж байна.

Энэ утгаараа эдгээр аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд бүхэлд нь хяналт тавьж чадах зохицуулалтын тогтолцоо нэн тэргүүнд шаардлагатай бөгөөд үүнээс шалтгаалан санхүүгийн зах зээлийн хөгжил, тэдгээрийн зах зээлийн идэвх, хөрөнгө оруулагчдын цаашдын хандлага, үр ашиг хамаардаг. Иймд зохицуулалтын байгууллагын хүний нөөцийн чадавхийг нэмэгдүүлж өөрөө өөрийгөө зохицуулагч байгууллагын эрх зүйн чадамжийг дээшлүүлэх шаардлагатай байна.

3. Мэргэжлийн оролцогч байгууллагуудын санхүүгийн чадавхи хангалттай бус, иргэдийн идэвхи оролцоо, санхүүгийн чадамж сул, зөвхөн тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлдэг учраас санхүүгийн бусад салбартай өрсөлдөх чадвар сул байна.

4. Хувьчлалын сөрөг үр дагавраас үүдэн хөрөнгийн зах зээлийн ач холбогдлыг иргэд ойлгоогүй байгаа нь нийтэд санал болгон үнэт цаас гаргахад тодорхой сөрөг үр дагаврууд авчирч байна. Хөрөнгө оруулах шийдвэрийн хариуцлагыг хөрөнгө оруулагч өөрөө хүлээх үнэт цаасны зах зээлийн үндсэн зарчмын ойлголт дотоодын жижиг хөрөнгө оруулагч нарт тогтоогүй нь өнгөрсөн хугацаанд хөрөнгийн зах зээлд өрнөсөн зарим үйл явдлаас харагдаж байна. Олон нийтийн мэдээлэл хүлээж авах ухамсар тогтоогүй төдийгүй үнэт цаасны зах зээлийн тухай мэдлэг, ойлгоцын хөгжил хэт удаан байгаа нь үүнд нөлөөлж байна.

III. Зах зээл дэх бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, хөрвөх чадварыг сайжруулах зорилтын хүрээнд:

Амжилт

1. 2005 оноос хойш үнэт цаас гаргах Хөрөнгийн биржид бүртгэлтэй болох үйл явцыг дэмжсэнээр 2012 хүртэл нийт 17 хувьцаат компани шинээр болон нэмж үнэт цаас гаргаад байгаа бөгөөд энэ нь “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн нийт арилжааг 23.4 хувиар нэмэгдүүлжээ. Эдгээрээс 53 хувь нь олборлох болон боловсруулах салбарын аж ахуй нэгжүүд байгаа нь тэдэнд хөрөнгийн зах зээлээс санхүүгийн эх үүсвэр татаж, түүгээрээ нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөөц бололцоо буйг харуулж байна.

2. Бондын арилжаа мөн 2006 оноос идэвхжиж хөрөнгийн зах зээлээс нийтдээ 341,3 тэрбум төгрөгийн хөрөнгө татан төвлөрүүлсэн байна. Ялангуяа 2010, 2011 онуудад идэвхтэйгээр бонд гаргасан. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны эрх зүйн орчин бий болсноор 3 багц үл хөдлөх хөрөнгөөр баталгаажсан бонд гаргаад байна.

3. “Эрдэнэс таван толгой” ХК-ийн хувьцааг нийтэд хуваарилахтай холбогдуулан 2010 оноос иргэдийн үнэт цаасны зах зээлд оролцох оролцоо идэвхжсэн.

Сорилт

1. Монголбанкны Ерөнхийлөгч болон Сангийн сайдын 2012 оны 217/А-161 тоот хамтарсан тушаалаар “Засгийн газрын үнэт цаас гаргах, арилжаалах тухай журам”-ыг батлан Засгийн газрын үнэт цаасны хоёрдагч зах зээлийн арилжааг зохицуулалттай үнэт цаасны зах зээлээс гадуур, тусгай зөвшөөрөл бүхий арилжаа эрхлэх байгууллага уг арилжааг зохион байгуулахаар байгаагаар нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.2, 21.1-д заасныг зөрчсөн, Банкуудаас бусад хувь хүн, хуулийн этгээдийн эрх ашиг хөндөгдөх магадлалтай тул тэдгээрийн Засгийн газрын үнэт цаасыг худалдан авах, үр шимийг хүртэх боломжийг тодорхой хэмжээгээр хязгаарлаж, зөвхөн банкны салбарыг дэмжсэн, бондын өртгийг нэмэгдүүлэх өрөөсгөл зохицуулалт болсон.

2. Салбарын өсөлтийг дэмжихүйц хууль тогтоомжийн тогтолцоо бүрэлдээгүй, зах зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний сонголт хомс, үнэт цаасаар хөрөнгө татан төвлөрүүлэх зах зээлийн багтаамж бага, зах зээлд боломжит хэмжээнд шинэ бараа бүтээгдэхүүн нийлүүлэгдэхгүй байгаа нь үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж буй компаниудын дийлэнхи нь алдагдалтай ажиллаж байгаагаас харж болно.

3. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газрын ашиглалтын лицензийг эзэмшигчид “Ашигт малтмалын тухай” хуульд заасны дагуу нийт хувьцааны 10 хувийг Хөрөнгийн биржээр арилжаалах тухай хуулийн заалт өнөөдрийг хүртэл хэрэгжихгүй байна.

IV. Хөрөнгө оруулагчдыг идэвхжүүлэх, тэдний эрх ашгийг хамгаалах, зах зээлийн бус эрсдлийг бууруулах, томоохон сангууд хөрөнгийн зах зээлд оролцох боломжийг бүрдүүлэх замаар хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд

Сорилт: Гадаад болон дотоодын мэргэжлийн хөрөнгө оруулагчын тоог нэмэгдүүлж, зах зээлийн хөрвөх чадвар, багтаамжийг сайжруулахад чухал нөлөө үзүүлэх хамтын хөрөнгө оруулалтын байгууллага буюу хөрөнгө оруулалтын сан мөн зохицуулалтын байгууллагын хяналт дор үйл ажиллагаа явуулдаг, хөрөнгө оруулалтыг гэрээгээр удирдан мэргэжлийн түвшинд хэрэгжүүлдэг байгууллагын орон зай үгүйлэгдэж байна.

Өнгөрсөн хугацаанд хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин бүрэн бүрэлдээгүй байснаас хөрөнгө оруулалтын сангаар дамжин Монгол Улсын үнэт цаасны зах зээлд орж ирэх тогтмол мөнгөний урсгал бий болоогүй бөгөөд үүнээс шалтгаалан уул уурхайн салбарын өсөлтөөс шалтгаалж гэнэт мөнгөний урсгал орж ирснээр хөөс үүсэх, мөн гэнэт гарах байдлаар зах зээлийг шокийн байдалд оруулах магадлал улам өндөр болж байна.

Хэдийгээр хөрөнгө оруулалтын сангийн хуулийн төсөл боловсруулагдаж байгаа боловч энэ ажлыг цаашид түргэвчлэх шаардлагатай байна. Ирээдүйд гадаадын болон дотоодын тэтгэврийн болон бусад сангууд тус зах зээлийн өндөр эрсдлийн түвшнээс хамаарч үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулахгүй байх магадлал өндөр байна. Үнэт цаасны зах зээлийн хөгжлийн эхэн үед байгуулагдаж байсан хөрөнгө оруулалтын сангууд үндсэн үйл ажиллагааны чиглэлээрээ ажиллаж чадаагүй төдийгүй эдгээр нь удирдлага зохион байгуулалтын хувьд бэхжээгүй ёс зүйн хувьд төлөвшөөгүй, хууль эрх зүйн зохицуулалт дутмаг байснаас үүдэн хамтын санд цэнхэр, ягаан тасалбараа нийлүүлэн хөрөнгө оруулсан иргэдийн хөрөнгийг шамшигдуулах, хөрөнгийг үнэгүйдүүлэх үйлдлийг нилээд гаргаж байсан тул дээрх сангуудын үйл ажиллагааг зогсоон, иргэдэд их хэмжээний хохирол учруулсан сангуудын удирдлагыг холбогдох хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулж байв.

Тиймээс хөрөнгө оруулалтын сан буюу хамтын сангийн гажуудалд хүрсэн гашуун туршлагыг хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн төслийг боловсруулахад анхаарах нь зүйтэй.

V. Үнэт цаасны зах зээлийн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилтын хүрээнд

Амжилт

Компанийн тухай хуулийг шинэчлэн найруулснаар “нэгдмэл сонирхолтой этгээд”-ийн тухай ойлголтыг тодорхой болгон өргөжүүлэх замаар хувьцаат компанийн хувьцааны багцыг эзэмшигчдийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, зохицуулагч байгууллагын хувьд хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах тодорхой бүрэн эрх олгох /шүүхэд хандах, татан буулгах, өөрчлөн байгуулах г.м/, тендер санал гаргах, хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай болгон өөрчлөх үед хувьцааг эргүүлэн худалдаж авах үнийг тодорхойлох зарчмыг өөрчлөх, ТУЗ хараат бус гишүүдтэй байх шаардлагыг хуульчлах, хараат бус гишүүнд нэр дэвшүүлэх, сонгох, тэдгээр гишүүд нь үйл ажиллагаагаа тайлагнах журмыг хуульчлах, хөрөнгө оруулагчдыг мэдээллээр хангах, компанийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах

чиглэлээр ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үүрэг хариуцлагыг тодорхой болгох зорилтууддаа амжилттай хүрч чадсан байна.

Түүнчлэн, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль 2010 онд батлуулж хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган, үл хөдлөх хөрөнгийн болон бусад зээлийг үнэт цаасжуулан хөрөнгийн зах зээлд арилжсанаар шинэ хямд эх үүсвэр татах эрх зүйн орчин бий болгож чадсан.

Сорилт

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг шинэчлэн найруулж өнөөгийн зах зээлийн шаардлагад нийцүүлэх ажил 2008 оноос хойш хийгдэн хуулийн төслийг боловсруулсан боловч уг хуулийн төслийг батлуулах ажил удаашралтай байна. 2012 оны УИХ-ын сонгуулийн дараа хуулийн төслийг Засгийн Газар эргүүлэн татаж ахин өргөн барих ажил явагдаж байгааг түргэвчлэх шаардлагатай байна.

Хөрөнгө оруулалтын сангийн эрх зүйн орчинг яаралтай бий болгох шаардлагатай байна. Хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг Эдийн засгийн хөгжлийн яаманд байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд уг хуулиар хөрөнгө оруулалтын санг Монгол Улсад байгуулах төдийгүй гадаадын хөрөнгө оруулалтын сан Монголын хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах болон үйл ажиллагаа явуулахад шаардлагатай эрх зүйн орчинг бий болгоход чиглэж байна.

Дээрх шинжилгээнээс нэгтгэн дүгнэвэл, цаашид бидэнд дараах сорилтууд тулгарсан хэвээр байна. Үүнд:

1. Зах зээлийн өсөлтийг дэмжихүйц хууль тогтоомжийн тогтолцоо бүрэн бүрэлдээгүй, хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй;
2. Даяаршил, технологийн дэвшлийн шаардлагад нийцэхүйц зах зээлийн дэд бүтцийг байгуулах явц удаан;
3. Хувьцаа болон бондын арилжаагаар хөрөнгө татах багтаамж бага хэвээр, үнэт цаасны хөрвөх чадвар, эргэлт, арилжааны идэвх бусад хөгжиж буй улсуудтай харьцуулахад сул;
4. Үнэт цаасны зах зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний сонголт хязгаарлагдмал;
5. Өмч хувьчлалаас үүссэн сөрөг үр дагаврууд бүрэн арилаагүй;
6. Үнэт цаасны зах зээлд итгэх хөрөнгө оруулагчдын итгэл, мэдлэг мэдээлэл бага;
7. Хувьчлалын үр дүнд бий болсон төдийгүй нийтэд хувьцаа гаргасан хувьцаат компаниудын засаглал сул хэвээр байгаагаас зах зээлийн нэр хүнд өсч чадахгүй байгаа зэрэг болно.

4. Үнэт цаасны салбарын стратеги төлөвлөгөө

4.1. Эрхэм зорилго

Монгол Улсын үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх Хорооны эрхэм зорилго нь хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй зах зээлийг бүрдүүлэхэд оршино.

4.2. Хэтийн зорилго

Монгол улсын үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх Хорооны хэтийн зорилго нь үнэт цаасны зах зээлд итгэх хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлж, системийн эрсдлийг бууруулан, санхүүгийн зах зээлд эзлэх хувийг өсгөж тэнцвэртэй санхүүгийн салбарыг хөгжүүлэхэд чиглэнэ.

4.3. Стратеги зорилго ба түүнийг хэрэгжүүлэх хөтөлбөр

Үнэт цаасны зах зээлд баримтлах стратеги зорилго нь үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх эрхэм зорилго, хэтийн зорилгодоо нийцэж тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.

Хорооны 2012 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 117 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны стратеги”-д үнэт цаасны зах зээлд Санхүүгийн зохицуулах хорооны баримтлах 4 стратеги зорилгыг “үнэт цаасны хороодын олон улсын байгууллагын стандарт, зарчимтай уялдаа холбоотой эрх зүйн орчинг бий болгон бэхжүүлэх, зуучлалын зах зээлийн хувьсал, өөрчлөлтийг танин мэдэх, системийн эрсдэлийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, бусад орны тэргүүн туршлага нэвтрүүлэх” гэж тодорхойлсон.

Эдгээр стратегид нийцсэн, үнэт цаасны зах зээлд тулгамдсан хэвээр байгаа бэрхшээл, сорилтыг давахад чиглэсэн дараах хөтөлбөрийг дэвшүүлж тэдгээрийн дагуу хэрэгжүүлэх үйл ажиллагааг доорх байдлаар тодорхойлж байна:

- 1. Үнэт цаасны зах зээлийн зохицуулалтыг олон улсын стандартад нийцүүлэх**
 - 1.1. Шаардлагатай хууль тогтоомж батлах;
 - 1.2. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах.
- 2. Мэргэжлийн зуучлалын үйл ажиллагааны чанарыг сайжруулах, дэд бүтцийг хөгжүүлэх**
 - 2.1. Үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлэх;
 - 2.2. Харилцагчдад хүртээмжтэй, зардал багатай, өрсөлдөөн бүхий, үйлчилгээний өндөр чанартай мэргэжлийн зуучлалын үйл ажиллагааг бий болгох;
 - 2.3. Мэргэжлийн байгууллагад ажиллаж буй мэргэжилтнүүдийн чадавхи, ёс зүйг дээшлүүлэх;

2.4. Үнэт цаасны зах зээлд тогтвортой мөнгөний урсгал бий болгох.

3. Системийн эрсдэлийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх

- 3.1. Мэргэжлийн байгууллагын эрсдэлийн удирдлагыг боловсронгуй болгох, хөрөнгийн чадавхийг нэмэгдүүлэх;
- 3.2. Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн санд үндэслэсэн хяналт, шинжилгээ судалгааны тогтолцоог сайжруулах;
- 3.3. Эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог бий болгох;
- 3.4. Үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн системийг сайжруулах;
- 3.5. НББ-ийн олон улсын стандартад шилжих үйл ажиллагааг үнэт цаасны зах зээлийн оролцогчдын хувьд тусгай хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэх;
- 3.6. Аудит, үнэлгээ, зээлжих чадавхийн зэрэглэл тогтоох үйлчилгээг дэмжих;
- 3.7. Үнэт цаасны зах зээлийн төрийн зохистой зохицуулалт, хяналтын тогтолцоог бий болгох.

4. Үнэт цаас гаргагчтай холбоотой үйл ажиллагаанд олон улсын тэргүүн туршлага нэвтрүүлж хэвшүүлэх

- 4.1. Мэдээллийг нээлттэй болгох, хөрөнгө оруулагчдад хүргэх тэргүүлэх системийг нэвтрүүлэх;
- 4.2. Үнэт цаас гаргагчдад сайн засаглалыг төлөвшүүлэх.

5. Хөрөнгө оруулалтын эрхийн бичгийн хувьчлалын сөрөг үр дагаврыг залруулах

- 5.1. Хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр хувьцаа эзэмшсэн, идэвхгүй хөрөнгө оруулагчдын болон хөрөнгө оруулалтын сангийн хувь нийлүүлэгчдийн асуудлыг нэгмөр шийдвэрлэх;
- 5.2. Өмч хувьчлалын үр дүнд бий болсон хувьцаат компаниудыг зэрэглэх, Хөрөнгийн биржийн жагсаалтыг “цэвэрлэх”.

6. Зах зээл дэх бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, хөрвөх чадварыг сайжруулах

- 6.1. Зах зээлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх;
- 6.2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх;
- 6.3. Санхүүгийн шинэ хэрэгсэл бий болгох;
- 6.4. Хөрвөх чадварыг нэмэгдүүлэх.

Хөтөлбөр, түүний дагуу хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг дараах 4.4 дэх хэсэгт хүснэгт хэлбэрээр үзүүлэв.

4.4. Стратеги зорилгыг хэрэгжүүлэх хөтөлбөр, түүний төлөвлөгөө

Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Үйл ажиллагааны хүрээнд гүйцэтгэх ажлууд	Хугацаа
<p>1. Үнэт цаасны зах зээлийн зохицуулалтыг олон улсын стандартад нийцүүлэх</p> <p>1.1. Үнэт цаасны зах зээлийн зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа</p> <p>1.1.1. Шаардлагаар тогтоомж хууль батлах</p> <p>1.1.2. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн төсөл батлуулах</p> <p>1.1.3. Үнэт цаасны зах зээлд оролцогчдын хууль бус ажиллагаанд ногдуулах хариуцлагын хэм хэмжээг чангатгаж, хэрэг бүртгэлийн ажиллагааг зохицуулах байгууллага шуурхай гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх чиглэлээр эрүүгийн хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулах</p> <p>1.1.4. Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд хийгдэх ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох</p> <p>1.1.5. Үнэт цаасны зах зээлийн холбогдох олон улсын гэрээ, харилцан ойлголцлын санамж бичигт нэгдэн орох</p> <p>1.1.6. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу батлагдан гарах журам, стандарт, зааврыг</p>	<p>Төсөл боловсруулах ажлын хэсэгт орж ажиллах</p> <p>УИХ-д өргөн барихад бэлтгэх</p> <p>Эрүүгийн болон Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, үнэт цаасны зах зээл дээр үйлдэгддэг гэмт хэргийг хохирлын хэмжээгээр биш гэмт үйлдлийн /объектив тал/ мөн чанараар нь тодорхойлох журамд шилжих санал боловсруулах</p> <p>Төсөлд санал өгөх</p> <p>Үнэт цаасны зэх зээлд оролцогч мэргэжлийн байгууллага гэх мэт олон нийтийн эрх ашгийг хөндсөн санхүүгийн үйлчилгээг нийгэмд үзүүлж буй компаниудыг татан буулгах, дампууруулахтай холбоотой харилцааг нарийвчлан зохицуулах санал боловсруулах</p> <p>Үнэт цаасны хороодын Олон Улсын Байгууллага (IOSCO)-д санамж бичигт нэгдэн орох талаар идэвхи санаачилгатай ажиллах</p> <p>Бусад олон улсын гэрээ, санамж бичигт нэгдэн орох шаардлага, нөхцөл, боломжийг судлах</p> <p>Шинэчилсэн найруулгын дагуу шинээр бий болсон харилцааг зохицуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох</p>	<p>2013</p> <p>2013</p> <p>2013-2014</p> <p>2013</p> <p>2013</p>

	баглах	<p>Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн актуудыг шинэчлэн найруулах, шаардлагагай нэмэлт өөрчлөлтийг оруулах</p> <p>Шинэчилсэн найруулгын дагуу шинээр бий болсон харилцааг зохицуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох</p> <p>Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн актуудыг шинэчлэн найруулах, шаардлагагай нэмэлт өөрчлөлтийг оруулах</p>	2013
<p>1.2. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах</p>	<p>1.2.1. Шинээр батлагдан гарах хууль тогтоомжийг таниулан сурталчилах</p> <p>1.2.2. Зайны хяналт, газар дээрх шалгалтын чанарыг сайжруулах</p>	<p>Үнэг цаасны арилжаа, төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаанд мөрдөх журмыг нарийвчлан зохицуулж, олон улсын стандартад нийцүүлэх, арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлийн өмнөх болон дараах хяналт, зохицуулалтын чиг үүргийг тодорхой болгох, хөрөнгө оруулагч болон олон нийтэд өгөх мэдээллийн төрөл, хэлбэр, давтамжийг нарийвчлан тогтоох</p> <p>Хөрөнгийн зах зээлд ажил, үйлчилгээ эрхлэгчид ёсчлон мөрдөх ёс зүйн дүрэм /code of business conduct/, стандартыг тогтоон мөрдүүлэх</p> <p>Нийслэл хот, хөдөө орон нутагт иргэдэд таниулан сурталчилах сургалт зохион байгуулах</p> <p>Хөдөө орон нутагт хувьцааг компани, орон нутгийн төлөөлөгч нарг сургалт, семинар зохион байгуулах</p> <p>Олон нийтийн телевизтэй гэрээ байгуулж мэдээлэл тогтмол хургуулж ажиллах</p> <p>Мэргэжлийн байгууллагуудад сургалт явуулах, зөвлөмж, мэдээлэл хургуулэх</p> <p>Үнэг цаасны арилжаа, төлбөр, тооцоо, хадгаламжийн үйл явцад тавих хяналтыг тусгайлан цахим програмын дагуу хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, хяналтыг сайжруулах</p> <p>Мэргэжлийн байгууллагуудад эрсдэлд суурилсан</p>	2013-2016

		<p>хяналтыг хэрэгжүүлэх</p> <p>Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчдын үйл ажиллагаанд тавих зайны хяналтыг хэрэгжүүлэх цахим мэдээллийн сангийн агуулга бүтцийг сайжруулах</p> <p>Үнэт цаас гаргагчид хэрэгжүүлэх зохих хяналтын хэлбэрийг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх</p> <p>Үнэт цаасны зах зээлийн оролцогчдын өөрийгөө зохицуулах байгууллагын үйл ажиллагаа, ялангуяа хараат бус зах зээлийн хөгжлийн судалгааны институтийг бий болгохыг дэмжих</p> <p>Мэдээллийг нээлттэй болгох замаар олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг нэмэгдүүлэх</p>	
<p>2. Мэргэжлийн зуучлалын үйл ажиллагааны чанарыг хөгжүүлэх</p> <p>2.1. Үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлэх</p>	<p>1.2.3. Үнэт цаасны зах зээлийн оролцогчдын өөрийгөө зохицуулах байгууллага, олон нийтийн үнэт цаасны зах зээл дэх хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг дэмжих</p> <p>2.1.1. Үнэт цаасны төлбөр тооцооны системийг олон улсын стандартад нийцүүлэх</p> <p>2.1.2. Кастодианы үйлчилгээг нэвтрүүлэх</p> <p>2.1.3. Үнэт цаасны арилжааны системийг олон улсын стандартад нийцүүлэх</p>	<p>2. Мэргэжлийн зуучлалын үйл ажиллагааны чанарыг хөгжүүлэх</p> <p>Үнэт цаасны төлбөр тооцоо, клирингийн үйл ажиллагаанд SWIFT /ISO15022 олон улсын стандарт/-д нэвтрүүлэх</p> <p>Үнэт цаасны дансны бүртгэлийг цахимжуулах</p> <p>Иргэд өөрсдөө хадгаламжийн болон кастодиан банкаа сонгодог байх тогтолцоонд шилжих</p> <p>Зөвлөмж, мэдээлэл хүргүүлэх замаар кастодианы үйл ажиллагааг бодлогоор дэмжих</p> <p>Хөрөнгийн зах зээлд үнэ, ханш бодитоор тогтож, зах зээлийн хөрвөх чадвар тогтвортой байхад шаардлагаар дотоод хяналт, зохицуулалт, техник, технологийн шалгуур болон аргачлалыг тодорхой болгох</p> <p>Бүх аймаг, сумдад оршин сууж буй харилцагчдыг хамруулах боломжтой үнэт цаасны төлбөр тооцоо, мэдээлэл солилцооны дэд бүтцийг бий болгоход банкуудыг зуучлагчаар оролцуулах асуудлыг судлан хэрэгжүүлэх</p>	<p>2013-2015</p> <p>2015</p> <p>2013-2016</p>

	Харилцагчид электрон гарын үсэг ашиглаж үнэт цаасны арилжаанд оролцох боломжийг бий болгох арга хэмжээг хэрэгжүүлэх	Харилцагчид электрон гарын үсэг ашиглаж үнэт цаасны арилжаанд оролцох боломжийг бий болгох арга хэмжээг хэрэгжүүлэх Монгол индексийн загвар боловсруулах Индексийг зах зээлд турших Шинээр нэвтрүүлж буй индексийг зах зээлд таниулах, сурталчилах индексийг албан ёсоор нэвтрүүлэх	2014-2016
2.2. Харилцагчдад хүртээмжтэй, зардал багаай, өрсөлдөөн бүхий үйлчилгээний өндөр чанартай мэргэжлийн зуучлалын үйл ажиллагааг бий болгох	2.1.4. Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн үнэлгээг сайжруулах 2.1.5. Үнэт цаасны арилжаа эрхлэх, байгууллагын шинэчлэлийг дэмжих 2.2.1. Мэргэжлийн байгууллагын үйлчилгээний стандарт, чанарыг сайжруулах 2.2.2. Мэргэжлийн байгууллагын үйлчилгээний цар хүрээг өргөжүүлэх	2.1.5. Үнэт цаасны арилжаа эрхлэх, хадгаламжийн байгууллага, мэргэжлийн байгууллагын шинэчлэлийг дэмжих 2.2.1. Мэргэжлийн байгууллагын төлбөр тооцооны гүйцэтгэх, харилцагчдад үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх үйлчилгээний нийтлэг стандартыг тогтоон мөрдүүлэх Санхүүгийн баримтын бүртгэл, архивлалтыг сайжруулах Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчдын гадаад хамтын ажиллагааг дэмжих Хөдөө орон нутагт салбар байгуулахыг бодлогоор дэмжих	2013-2014
2.3. Мэргэжлийн байгууллагад ажиллаж буй мэргэжилтнүүдийн чадавхи, ёс зүйг дээшлүүлэх	2.3.1. Өөрийн зохицуулалттай байгууллагыг бэхжүүлж гишүүдийн мэргэжлийн ёс зүйн дүрэм, стандартыг тогтоон мөрдүүлэх, ёс зүйн хариуцлагын үндсийг бий болгох 2.3.2. Үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтэнд эрх олгох сургалтын системийг боловсонгүй болгох	Мэргэжлийн үйлчилгээний горим, заавар, зөвлөмж, гарын авлага боловсруулан мөрдүүлэх, нийтэд таниулах ажлыг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах Санхүүгийн сургалтын төв байгуулах, үйл ажиллагааг жигдрүүлэх Эдийн засаг, санхүү, хуулийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж буй их дээд сургуулиудын үнэт цаасны зах зээлээр мэргэшүүлэх хөтөлбөрийг зохих байгууллага,	2013-2016

		<p>мэргэжилтнүүдийн оролцоотойгоор боловруулж, сургалтыг эхлүүлэх</p>	
<p>2.4. Үнэт цаасны зах зээлд тогтвортой мөнгөний урсгал бий болгох</p>	<p>2.3.3. Монголын үнэт цаасны зах зээлийн мөргэжилтнүүдийг Итгэмжлэгдсэн санхүүгийн шинжээчдийн /CFA/ болон Олон Улсын хөрөнгө оруулалтын магадлан итгэмжлэгдсэн шинжээчдийн холбоо /АСПА/-дын сургалт, шалгалтад хамруулахад бодлогоор дэмжих</p> <p>2.3.4. Санхүү, хөрөнгө оруулалтын мэргэжлийн холбоодод дэмжлэг үзүүлэх</p> <p>Мэргэжлийн холбоодод дэмжлэг үзүүлэх</p> <p>Мэргэжлийн холбоодыг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын байгууллагад гишүүнээр элсэх зэргээр монголын мэргэжилтнүүд олон улсын байгууллагуудтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх</p> <p>Үйл ажиллагаандаа олон улсын стандарт нэвтрүүлэх, магадлан итгэмжлэлд хамрагдахад дэмжлэг үзүүлэх</p> <p>Хөрөнгө оруулалтын сан байгуулагдах, сангийн хөрөнгийг итгэмжлэн удирдах, бүртгэх, хадгалах, сангийн гаргасан үнэт цаасыг байршуулах, эргэлтэнд оруулах, худалдан авахтай холбогдсон харилцааг зохицуулж, хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг бүрдүүлэх</p> <p>Үнэт цаасны зах зээлд банк, банк бус санхүүгийн болон арилжааны даатгалын байгууллагаас явуулах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох</p> <p>Хөрөнгө оруулалтын сангууд бий болох үйл явцыг дэмжих</p> <p>Тэтгэврийн санг бие даалгах, зах зээлийн зарчмынх нь дагуу удирдах үйл ажиллагааг эхлүүлэх талаар холбогдох яамтай хамтран ажиллах</p> <p>Урт хугацааны болон хувийн тэтгэврийн үйлчилгээг дэмжиж, эрх зүйн орчныг бүрдүүлэх</p> <p>Хөрөнгийн зах зээлд банкны оролцоог дээшлүүлэх, нэг цэгийн үйлчилгээ бий болгох</p>	<p>2013-2016</p>	

	<p>2.4.2. Үнэт цаасанд хөрөнгө оруулахыг татварын бодлогоор дамжуулан дэмжих</p>	<p>Гадаадын институционал хөрөнгө оруулагч үнэт цаасны зах зээлд оролцох бололцоог нэмэгдүүлэх, орчинг бий болгох</p>	<p>2014</p>
<p>3. Системийн эрсдэлийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх</p> <p>3.1. Мэргэжлийн байгууллагын эрсдэлийн удирдлагыг боловсронгуй болгох, хөрөнгийн чадавхийг нэмэгдүүлэх</p> <p>3.2. Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн санд Үндэслэсэн хяналт, шинжилгээ судалгааны тогтолцоог сайжруулах</p> <p>3.3. Эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог бий болгох</p> <p>3.4. Үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн системийг сайжруулах</p>	<p>3.1.1. Мэргэжлийн байгууллагуудын эрсдэлийн үнэлгээний аргачлал, хөрөнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоон мөрдүүлэх, эрсдэлийн үнэлгээг тогтмолжуулах, явцын хяналтыг сайжруулах, сайн дураар эрх зүйн болон ёс зүйн хэм хэмжээ дагаж мөрдөх явдлыг хэвшүүлэх</p> <p>3.1.2. нэгдэх, нийлэх замаар мэргэжлийн байгууллагууд өргөжих, чадавхиа дээшлүүлэхэд бодлогоор дэмжих</p> <p>3.2.1. Үнэт цаасны зах зээл, түүнд оролцогчдын үйл ажиллагааны талаар дүн шинжилгээ хийх боломж бүхий мэдээллийн нэгдсэн санг тогтмол бүрдүүлэх</p> <p>3.2.2. Мэдээллийн нэгдсэн санд тогтмол судалгаа, дүн шинжилгээ хийх</p> <p>3.3.1. Мэргэжлийн байгууллагын эрсдэлийн үнэлгээнд тавих төрийн тавих хяналтыг сайжруулж, эрсдэлийг бууруулах нөхцлийг бүрдүүлэх</p> <p>3.4.1. Үнэт цаасны зээлийн үйлчилгээ нэврүүлэх</p> <p>3.4.2. Эргүүлэн худалдан авах буюу худалдах нөхцөлтэйгээр үнэт цаас худалдах буюу худалдан авах үйлчилгээг нэвтрүүлэх</p>	<p>2013-2014</p> <p>2013-2016</p> <p>2013</p> <p>2015</p>	

<p>3.5. НББ-ийн олон улсын стандартад шилжих үйл ажиллагааг үнэт цаасны зах зээлийн оролцогчдын хувьд тусгай хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэх</p>	<p>3.5.1. Үнэт цаасны зах зээлд оролцогчдод зориулсан бүртгэл, тайлангийн олон улсын стандартад нийцсэн сурах бичиг, гарын авлага боловсруулж бэлтгэх</p> <p>3.5.2. Мэргэшсэн нягтлан бодогчдын институттэй хамтран үнэт цаасны зах зээлд оролцогч байгууллагуудын мэргэжилтэн, нягтлан бодогч нарыг сургах, давтан сургах</p> <p>3.5.3. Энэ талаар төрийн эрх бүхий байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, сурталчлан таниулах зэрэг арга хэмжээг авах</p>	<p>2013-2014</p>
<p>3.6. Аудит, үнэлгээ, зээлжих чадварын зэрэглэл тогтоох үйлчилгээг дэмжих</p>	<p>3.6.1. Зээлжих чадварын зэрэглэл тогтоох үйл ажиллагааны эрх зүйн болон зах зээлийн хөшүүргийг бий болгох</p> <p>3.6.2. Үнэлгээ, зээлжих чадварын зэрэглэл тогтоох үйл ажиллагаанд хэрэглэдэг нийтлэг аргачлалыг тогтоох</p> <p>3.6.3. Зээлжих чадварын зэрэглэл тогтоох үйлчилгээ үзүүлэх байгууллага нэмэгдэхэд бодлогын дэмжлэг үзүүлэх</p> <p>3.6.4. Зээлжих чадварын зэрэглэл тогтоох үйлчилгээ үзүүлэх байгууллага хоорондох өрсөлдөөнийг дэмжих</p> <p>3.6.5. Аудит, үнэлгээ, зээлжих чадварын зэрэглэл тогтоох үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллага, мэргэжилтнийг мэргэжлийн хариуцлагын даатгалд хамруулах эрх зүйн үндсийг бий болгох</p>	<p>2013-2015</p>
<p>3.7. Үнэт цаасны зах зээлийн төрийн зохистой зохицуулалт, хяналтын тогтолцоог бий болгох</p>	<p>3.7.1. Санхүүгийн салбарт тулгамдаж буй асуудлын шалтгаан, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний асуудлаар зөвлөлдөх чиглэлээр Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах</p> <p>3.7.2. Санхүүгийн нэгдлийн нэгдсэн хяналтын тогтолцоог бий болгох</p> <p>Санхүүгийн зах зээлд оролцогчдын талаар төрийн байгууллагуудад төвлөрч буй мэдээллийн нэгдсэн сан, зайны болон газар дээрх хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах /Монголбанк, Хуулийн этгээдийн бүртгэл, тагвар төлөгчийн мэдээлэл, иргэний болон эд хөрөнгийн бүртгэлийн мэдээлэл, хууль хяналтын байгууллага, шүүхийн шийдвэр, шийдвэр гүйцэтгэх байгууллага, өр барагдуулах алба/</p>	<p>2013-2016</p>

		<p>Төрийн байгууллагуудад төвлөрч буй мэдээллийг нэгтгэсэн мэдээллийн санг үнэт цаас гаргагч, хамтын хөрөнгө оруулалтын болон өөрийгөө зохицуулах байгууллага, мэргэжлийн байгууллага бүрээр бүрдүүлэх</p> <p>Мэдээллийн санд тулгуурлан компанийн нийгмийн хариуцлага, засаглалын байдалд нэгдсэн дүгнэлт өгөх, аливаа тендер болон бусад шалгаруулалтад ашиглах, эрх бүхий албан тушаалтан нь тохиромжтой этгээд мөн болох талаар дүгнэлт өгөх боломж бүрдүүлэх</p>	
<p>4. Үнэт цаас гаргагчтай холбоотой үйл ажиллагаанд олон улсын тэргүүн туршлага нэвтрүүлж хэвшүүлэх</p> <p>4.1. Мэдээллийг нээлттэй болгох, хөрөнгө оруулагчдад хүргэх тэргүүлэх системийг нэвтрүүлэх</p>	<p>4.1.1. Хорооноос үнэт цаасны зах зээлтэй холбогдон гарч буй шийдвэр, мэдээлэл, судалгаа, тайлан, дүн шинжилгээг нээлттэй ил тод болгох</p> <p>4.1.2. Хороо, арилжаа эрхлэх байгууллага болон бүртгэлтэй компани хоорондын мэдээллийн тогтмол эргэх холбоо үүсгэх</p> <p>4.1.3. Хувьцаат компаниудын үйл ажиллагаанд тавих хяналтын илүү үр ашигтай, төвлөрсөн хяналтын зарчмыг (Disclosure-Based Regulation) нэвтрүүлэх</p> <p>4.1.4. Үнэт цаас гаргагч болон үнэт цаасны зах зээлийн бусад оролцогчдын үйл ажиллагааны тухай мэдээллийг хөрөнгө оруулагч болон бусад сонирхогч этгээдэд нээлттэй болгох журмыг боловсронгуй болгох</p> <p>4.1.5. Хувьцаат компанийн үйл ажиллагаатай холбоотой нийтэд нээлттэй болгох мэдээллийг тодорхой болгох</p> <p>4.1.6. Хувьцаат компаниуд мэдээллээ нийтэд хүргэх зардлыг бууруулах зорилгоор дүрэмдээ заасан бол компанийхаа веб сайтаар, цөөн хувьцаа эзэмшигчидтэй бол хаягаар нь хүргэдэг байх журам тогтоох</p>	<p>2015-2016</p>	
<p>4.2. Үнэт цаас гаргагчдад засаглалыг төлөвшүүлэх</p>	<p>4.2.1. Компанийн засаглалын кодексийг бүртгэлтэй компанийн удирдлагад сурталчлах сургалтыг бүсчилсэн байдлаар зохион байгуулах</p> <p>4.2.2. Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг дүгнэх аргачлал боловсруулан, жил бүр дүгнэж байх</p> <p>4.2.3. Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэхэд Хөрөнгийн бирж, Компанийн засаглалын хөгжлийн төв болон бусад төрийн бус байгууллагын оролцоог идэвхжүүлэх</p>	<p>2013-2016</p>	

5. Хөрөнгө оруулалтын эрхийн бичгийн хувьчлалын сөрөг үр дагаврыг залруулах		2013-2016
5.1. Хөрөнгө оруулалтын эрхийн хувьцаа эзэмшсэн, идэвхгүй хөрөнгө оруулагчдын болон хөрөнгө оруулалтын сангийн хувь нийлүүлэгчдийн асуудлыг нэгмөр шийдвэрлэх	<p>5.1.1. Хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр хувьцаа эзэмшигч болсон иргэд төвлөрсөн хадгаламжид дансаа нээлгэх ажиллагааг дуусгах тодорхой хугацаа тогтоох талаар УИХ-д санал хүргүүлэх</p> <p>5.1.2. Тогтоосон хугацаанд дансаа нээлгээгүй, үлдэгдлээ шалгаж багалгаажуулаагүй иргэдийн дансанд байгаа хөрөнгийг төвлөрүүлэн хадгалах, оновчтой удирдан, үр ашигтай хэлбэрээр байршуулах, шаардсан үед нь буцаан олгох зохистой хэлбэрийг сонгон хэрэгжүүлэх</p> <p>5.1.3. татан буугдсан хөрөнгө оруулалтын сангийн гишүүдийн хөрөнгийн асуудлыг нэгмөр шийдвэрлэх</p>	
5.2. Өмч хувьчлалын үр дүнд бий болсон хувьцаат компаниудыг зэрэглэх, Хөрөнгийн биржийн жагсаалтыг “цэвэрлэх”	<p>5.2.1. Өмч хувьчлалын явцад үүсэн бий болж, Хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэгдсэн компанийг зэрэглэх</p> <p>5.2.2. Хөрөнгийн биржийн бүртгэлийн шаардлагыг хангахгүй байгаа компанийг бүртгэлээс хасах, үйл ажиллагаа нь зогссон боловч хөрөнгө нь байгаа компанийг дахин хөрөнгөжүүлэх үйл ажиллагаанд боломжтой дэмжлэг үзүүлэх</p> <p>5.2.3. Хөрөнгө нь үрэгдсэн компанийг таган буулгах арга хэмжээг шаг дараатай авч хэрэгжүүлэх ингэхдээ ХОЭБ-ээр хувьцаа эзэмшсэн иргэдийн өмчлөх эрхийг аль болох хохиролгүйгээр шийдвэрлэх</p> <p>5.2.4. компанийг алдагдалд оруулсан, дампуурах байдалд хүргэсэн эрх бүхий албан тушаалтнуудад хариуцлага ногдуулах талаар идэвхтэй ажиллах</p>	2013
6. Зах зээл дэх бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, хөрвөх чадварыг сайжруулах		
6.1. Зах зээлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх	<p>6.1.1. “Ашигт малтмалын тухай” хуульд заасны дагуу хувьцаагаа Монголын хөрөнгийн биржид бүртгүүлж, арилжаалах ажиллагааг эхлүүлэх</p> <p>6.1.1.1. “Ашигт малтмалын тухай” хуульд заасны дагуу хувьцаагаа Монголын хөрөнгийн биржид бүртгүүлж, арилжаалах ажиллагааг эхлүүлэх талаар холбогдох яам, агентлагтай хамтран ажиллах</p> <p>Орд газрыг эзэмшигч этгээдийн үнэт цаасыг Монголын болон гадаад орны бирж дээр зэрэг арилжаалах боломж олгодог Монголын хадгаламжийн бичиг гаргах зэрэг зах зээлийн арга хэрэглүүрийг ашиглах эрх зүйн</p>	2013-2016

	<p>6.1.2. Төрийн өмчит компанийг хувьцаат компани болгон хувьчлахад төрийн баримтлах бодлогыг тодорхой болгох</p>	<p>зохицуулалтыг бий болгох</p> <p>Төрийн өмчит компаниудыг бүрэн хувьчлахаас өмнө хяналтын бус хувийг жижиг багцаар, тухайлбал, 5-10 хувиар багцлан хөрөнгийн зах зээл дээр арилжаалах бодлогыг хэрэгжүүлэх талаар Засгийн Газарт санал хүргүүлэх, Төрийн өмчийн хороогой хамтран ажиллах</p> <p>Эдгээр үнэт цаасыг тэтгэврийн болон хамтын хөрөнгө оруулалтын сангууд, хөрөнгө оруулалтын банкны болон андеррайтерийн компаниуд, компанийн ажиллагсдын баг худалдан авахыг дэмжих</p> <p>Хөрөнгө оруулагчдад хэт том багц төвлөрөх явдлыг хязгаарлах бодлого баримтлах талаар Засгийн газар, холбогдох яам, агентлагтай хамтран ажиллах</p>	2013-2015
<p>6.1.3. Гадаадын үнэт цаасыг Монголын үнэт цаасны зах зээлд арилжаалах нөхцлийг бүрдүүлэх</p>	<p>Олон улсын үнэт цаасны зах зээлийн хэрэгслүүд харилцан нэвтрэх боломжийг либералчлах чиглэлээр Санхүүгийн зохицуулах хороо Олон улсын Үнэт цаасны хороодын холбооны гишүүн орнуудтай харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурах ажлыг эрчимжүүлэх</p> <p>Хил дамнасан арилжааны тогтолцоог бий болгох судалгааны ажлыг явуулах</p>	2014-2015	
<p>6.1.4. Дотоодын үнэт цаас гаргагчдыг үнэт цаасны зах зээлд татан оролцуулах</p>	<p>Үнэт цаасаа олон улсын зах зээлд арилжаалах хүсэлтэй Монгол Улсын хуулийн этгээд Монголын үнэт цаасны зах зээлд үнэт цаасаа гаргахыг дэмжих орчинг бүрдүүлэх</p> <p>Үнэт цаасны бүртгэлийн журмыг үнэт цаас гаргагчдын үйл ажиллагааны онцлог, хөрөнгө татах чадварыг харгалзан ялгавартай тогтоох</p>	2013	
<p>6.1.5. Засгийн газар, орон нутгийн болон компанийн өрийн бичгийн анхдагч болон хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх</p>	<p>Засгийн газрын өрийн бичгийн зах зээлийг төлөвшүүлж, үнэт цаасны зах зээлд жишиг хүү /benchmark/-ийг бий болгох</p> <p>Засгийн газрын богино буюу урт хугацааны хөрөнгө</p>	2013-2016	

		<p>оруулалтын төлөвлөгөөг санхүүжүүлэх эх үүсвэрийг бүрдүүлэх механизмыг боловсруулах</p> <p>Монголбанкаас мөнгөний бодлогыг явуулахдаа тус банкны үнэт цаас бус Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлээр дамжуулан явуулахыг бодлогоор дэмжих, зах зээл дэх мөнгөний нийлүүлэлт, таталтыг олон улсын жишгээр явуулах оновчтой хэлбэрийг бий болгох, цаашид эрчимтэй хөгжүүлэх</p> <p>Өрийн бичгийн прайм дилерийн арилжааны тогтолцоог нэвтрүүлэх</p> <p>Өрийн бичгийн зах зээлд олон улсын томоохон банк санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулалтын сангуудыг таган оролцуулах, технологийн шийдлийг нэвтрүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлэх</p>	
<p>6.2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх</p>	<p>6.2.1. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч байгууллагуудыг бэхжүүлэх чиглэлээр холбогдох яам газруудтай хамтран ажиллах</p> <p>6.2.2. Хөгжлийн банк, орон сууцны санхүүжилтийн корпораци зэрэг байгууллагуудаас гаргасан үнэт цаасыг худалдан авахад тэтгэврийн сангийн хөрөнгийг ашиглах бодлого баримтлах</p>		2013-2016
<p>6.3. Санхүүгийн шинэ хэрэгсэл бий болгох</p>	<p>6.3.1. Шинэ төрлийн үнэт цаас бий болгох</p> <p>6.3.2. Деривативын зах зээлийг хөгжүүлэх арга хэмжээ авах</p>	<p>Компаниудыг санхүүжүүлэх шинэ төрлийн үнэт цаас зах зээлд нэвтрүүлэх</p> <p>Шинэ төрлийн үнэт цаасны эрх зүйн зохицуулалтыг бий болгох</p> <p>Үнэлгээ өндөргэй, салбартаа тэргүүлэх үнэт цаас тогтоох, гаргахыг дэмжих</p> <p>Олон улсын зах зээлд түгээмэл хэрэглэгдэх опцион, фьючерсийг зах зээлд нэвтрүүлэх</p> <p>Хөрөнгө оруулагчдад суурь бүтээгдэхүүн, үнэт цаасны үнийн савалгаанаас үүдэлтэй эрсдлийг хедж механизмар бууруулах арга замыг нэвтрүүлэх</p>	2014-2016

		Деривативыг зөвхөн хувьцаа, өрийн бичгээс гадна түүхий эд, хөдөө аж ахуйн бараа бүтээгдэхүүн, валютын зах зээлд нэвтрүүлэх	2013-2014
6.4. Хөрвөх чадварыг нэмэгдүүлэх	6.4.1. Бүртгэлтэй компаниудад олон нийгэд чөлөөтэй арилжаалагдах хувьцааны доод хязгаарыг арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлийн шалгуураар тогтоох	Фьючерсийн зах зээлийг хөгжүүлснээр 24 цагийн арилжааг хийх боломжийг нээх	2015-2016 2013-2014

5. Хүлээгдэж буй үр дүн

Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ гэж тооцсон болно. Үүнд:

1. Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийг олон улсын жишигт нийцүүлэн, үйл ажиллагааны стандартыг сайжруулж, системийн эрсдлийг бууруулж уг зах зээлийг либеральчлах, гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчдад таатай орчныг бий болгосон байна.
2. Хөрөнгийн зах зээл дээр арилжаалагддаг санхүүгийн хэрэгслийг чанаржуулж, мэдээллийн нээлттэй байдал, олон нийтийн хяналтыг дээшлүүлж, зах зээлийн шударга практикийг хэвшүүлсэн байна.
3. Хөрөнгийн биржийн бүртгэлийн шаардлагыг олон улсын жишигт нийцүүлэн шаардлага хангасан компанийн хувьцаа нийтэд арилжаалагддаг болох нөхцлийг бүрдүүлэхийн хамт жижиг дунд үйлдвэрийн салбараас хөрөнгийн зах зээлд оролцох боломжийг давхар бүрдүүлнэ.
4. Хөрөнгө оруулагчдын эрх ашгийн хамгаалах эрх зүйн орчныг олон улсын стандартад хүргэн сайжруулж, өмч хувьчлалын улмаас үүссэн гажуудлыг арилгасан байна.
5. Хөрөнгийн зах зээл дэх мэдээллийг нээлттэй болгож, үнэт цаас гаргагчдын хувьд зохицуулалтын Мэдээлэлд суурилсан зохицуулалтын зарчим, мэргэжлийн оролцогчдын хувьд Эрсдэлд суурилсан зохицуулалтын зарчмыг нэвтрүүлсэн байна.
6. Өөрийгөө зохицуулах байгууллагын статусыг тодорхой болгохын хамт санхүүгийн бие даасан байдал, мэргэжилтнүүдийн чадавхийг дээшлүүлсэн байна.
7. Олон нийтийн санхүүгийн мэдлэг, боловсрол, сургалт, сурталчилгааны нэгдсэн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр 16-гаас дээш насны нийт иргэдийн талаас багагүй хувь нь хөрөнгө оруулалтын үндсэн мэдлэгтэй болсон, хөрөнгийн зах зээлд ямар нэг хэлбэрээр оролцдог болсон байна.
8. Санхүүгийн сургалтын төвийг байгуулж, үйл ажиллагааг нь жигдрүүлсэн байна.
9. Хорооны гадаад хамтын ажиллагааг бэхжүүлж, гадаадын зах зээлд үйл ажиллагаа явуулж буй дотоодын иргэн, хуулийн этгээд хийгээд дотоодын зах зээлд үйл ажиллагаа явуулж буй гадаадын иргэн хуулийн этгээдийн талаар мэдээлэл солилцох, хяналт тавих, туршлага солилцох боломжийг бүрдүүлсэн байна.

6. Санхүүжилт

Стратеги төлөвлөгөөний хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг улсын төсвийн хөрөнгөөс гадна Хорооны зохицуулалтын үйлчилгээний хөлс, гадаад дотоодын хандив, тусламж хийгээд бусад хөрөнгийн эх үүсвэрээр бүрдүүлж ажиллана.

7. Төлөвлөгөөний удирдлага, хяналт шалгалт, тайлагнал

Стратеги төлөвлөгөөг Хорооны болон Үнэт цаасны газрын жил, улирлын төлөвлөгөөгөөр дамжуулан хэрэгжүүлнэ. Стратеги төлөвлөгөөний биелэлтийн ерөнхий удирдлагыг Хорооны Ажлын алба, өдөр дутмын удирдлагыг Үнэт цаасны газрын дарга хариуцна.
